



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 177

Улаанбаатар хот

**“Төрийн орон сууцны корпораци” хязгаарлагдмал
хариуцлагатай компанийн 2024 оны эдийн засгийн
үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Онцгой нөхцөл
бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн орон сууцны корпораци” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. “Төрийн орон сууцны корпораци” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Э.Тамиртай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ шинэчлэн байгуулахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд чиглэл болгосугай..

3. Засгийн газрын 2025 оны “Эрчист Монгол” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 137 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган, зохион байгуулалтын арга хэмжээ авч, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ